



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

334.	Журамд нэмэлт оруулах тухай	Дугаар 197	1265
335.	Арьс, ширний үйлдвэрлэлийн төсөл дэмжих тухай	Дугаар 198	1266
336.	Татвараас чөлөөлөх тухай	Дугаар 199	1267
337.	Зарим компанийн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай	Дугаар 200	1267

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 6 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 197

Улаанбаатар хот

Журамд нэмэлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 2014 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Буянт-Ухаа 1 хорооллын орон сууцанд иргэдээс захиалга авах журам”-ын 6 дугаар зүйлд дараах хэсгийг нэмсүгэй:

“6.5. Хэрэв орон сууц худалдан авсан этгээд нь орон сууцны үлдэгдэл төлбөрийг төлөхөөр банк, банк бус санхүүгийн байгууллагаас ипотекийн зээл авбал зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцаа хөрөнгөөр хангуулах тохиолдолд журмын 4.3, 6.4 дэх заалт хамаарахгүй болно.”.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.САЙХАНБИЛЭГ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 6 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 198

Улаанбаатар
хот

Арьс, ширний үйлдвэрлэлийн төсөл дэмжих тухай

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2012 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 28/20 дугаар зөвлөмжийг үндэслэн, “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Үйлдвэрлэлийг дэмжих тухай” Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 141 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлд заасан “сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд” олгох эх үүсвэрээс 5.0 (таван) тэрбум, “ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлд” олгох эх үүсвэрээс 15.0 (арван таван) тэрбум, “оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлд” олгох эх үүсвэрээс 10.0 (арван) тэрбум төгрөгийг тус тус татан төвлөрүүлж, арьс, ширийг гүн боловсруулах болон түүгээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн төсөлд зориулан арилжааны банкаар дамжуулан зээл олгохыг Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаярт даалгаж, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д зөвшөөрсүгэй.

2. Хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох, түүнийг зориулалтын дагуу ашиглах, зээлийн эргэн төлөлтийн явцад хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Ш.Түвдэндорж, Эдийн засгийн хөгжлийн сайд Н.Батбаяр нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн 48 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ
АЖ АХУЙН САЙД**

Ш.ТҮВДЭНДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 6 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 199

Улаанбаатар
хот

Татвараас чөлөөлөх тухай

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13.1.4, 13.1.15, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 38.1.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршилтаар үржүүлэх болон сэргээн нутагшуулах зорилгоор гадаад орон, олон улсын байгууллагын буцалтгүй тусламжаар тахь адуу, цаа буга, азийн минжийг улсын хилээр оруулахад гаалийн албан татвар болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж байхыг Сангийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 6 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 200

Улаанбаатар
хот

Зарим компанийн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4.1, 16.4, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Татварын ерөнхий газар болон Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны санал, дүгнэлт, Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 145 дугаар шийтгэх тогтоолыг тус тус үндэслэн Хөвсгөл аймгийн “Хөвсгөл хүнс” ХК-ийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.

2. Өмнөговь аймгийн “Арвин сан” ХХК-ийн хүсэлт болон Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамнаас ирүүлсэн санал, дүгнэлтийг үндэслэн “Арвин сан” ХХК-ийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосугай.



3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Татварын ерөнхий газарт тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ
АЖ АХУЙН САЙД**

Ш.ТҮВДЭНДОРЖ

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.25

Индекс: 14003